

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.БАТСҮХ

2023 оны 03 дугаар сарын 14....

УДИРДАМЖ

2023 оны 03 дугаар сарын 14.

Улаанбаатар хот

“Харилцан хүндэтгэе” нөлөөллийн
аян зохион байгуулах тухай

Үндэслэл:

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.2 дэх хэсэгт “жендерийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ хэмээн заасан байдаг.

Аяны зорилго:

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.10 дахь хэсэгт заасан Жендерийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх чиг үүргийнхээ хүрээнд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан, жендерийн хэвшмэл ойлголтыг арилгах, эрэгтэй эмэгтэйчүүдэд тулгарч буй жендерийн асуудлын талаар мэдээллийг нэмэгдүүлэх албан хаагчдыг жендерийн мэдлэг мэдээлэлтэй мэдрэмжтэй болгоход аяны зорилго юм.

Энэ жилийн “НАДААС, ТАНИАС, БИДНЭЭС ЭХЛЭЛТЭЙ” гэсэн уриан дор нөлөөллийн ажил хийж хэрэгжүүлэхээр зорьж байна. Учир нь ялгавлан гадуурхалт нь өсвөр насны хүүхдүүдийн дунд бус насанд хүрэгчдийн дунд ч байдаг асуудал юм.

Аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Эсээ бичлэг уралдаан “Жендер гэж юу бэ?” дотооддоо албан хаагчид
2. “Жендерийн тухай ойлголт” сургалт дотооддоо албан хаагчид
3. Аяны хүрээнд зөвхөн батлагдсан лого, уриаг өөрсдийн цахим сүлжээнд байршуулж түгээх /гадагшaa иргэдэд
4. Албан хаагчид аяны хугацаанд үйл ажиллагааг дэмжиж, үйл ажиллагаагаа сулруулахгүй байх.

Хугацаа:

2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл

Хүрэх үр дүн:

Жендерийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, өргөжүүлэх. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтдаа тэгш боломж тэгш харилцаатай ажиллаж амьдрах эерэг хандлагыг нийгэмд бий болгох. Олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар жендерийн хэвшмэл буруу ойлголтыг арилна.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХУУГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Д.ГАНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 Б.ЭНХЦЭЦЭГ